



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 02 сарын 28 өдөр

Дугаар A/83

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6.“б”, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 02/01 дүгээр тогтоолоор батлагдсан “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Бүтээлч Өвөрхангай-2020” хөтөлбөрийн 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Онцгой байдлын газарт Япон Улсын Такикава хотоос бэлэглэж байгаа гал унтраах тусгай зориулалтын автомашин, түүний дагалдах хэрэгслийг тус хотоос Улаанбаатар хот хүртэл тээвэрлэх болон даатгалын зардалд бүгд 17.748.000 (арван долоон сая долоон зуун дөчин найман мянга) төгрөг, гадаад шилжүүлгийн зардалд 34.833 (гучин дөрвөн мянга найман зуун гучин гурав) төгрөг, нийт 17.782.833 (арван долоон сая долоон зуун наян хоёр мянга найман зуун гучин гурав) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлыг гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100177